



**УЛААНБААТАР ХОТЫН
ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ
ХӨТӨЛБӨР ТӨСЛИЙН НЭГЖ**

Соёлын төв өргөө Г корпус 411 тоот,
Амарын гудамж 2, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200 0061
Утас: (976) 7000 3099, Факс: (976) 7000 3098
Цахим шуудан: info@ub-subcenter.mn
Цахим хуудас: www.ub-subcenter.mn

2023.11.01 № 1206

танай _____-ны № _____-т

**ГНИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ГАЗАРТ**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн 3 дугаар үе шатны Толгойт дэд төвийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ  Д.АВИРМЭД



000000427



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

**“УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР” ТӨСӨЛ
ГУРАВДУГААР ҮЕ ШАТ**

**ТОЛГОЙТ ДЭД ТӨВИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:0004103/

2023

**“УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР” ТӨСЛИЙН
ГУРАВДУГААР ҮЕ ШАТ**

**“ТОЛГОЙТ ДЭД ТӨВ”-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:0004103/**

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Ж.БАТЗОЛБОО

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ

Д.АВИРМЭД

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

З.МӨНХ-ОРГИЛ

БОЛОВСРУУЛСАН:

“БАРУУН ХУАСАЙ” ХХК -ИЙН ЗАХИРАЛ



Ц.ТУЯАЦАЦРАЛ

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Ерөнхий мэдээлэл.....	3
1.2. Төслүүдийн товч танилцуулга, хэрэгжилтийн байдал.....	3
ХОЁР. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	11
2.1. БОМТ 2023 оны биелэлтийн зорилго, зорилт.....	11
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
3.1. Бизнес инкубатор, сургалтын төв төсөл (ТВС).....	12
3.2. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11C).....	16
3.3. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP)	19
ДӨРӨВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	24
ТАВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
ЗУРГАА. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	26
6.1. Бизнес инкубатор, сургалтын төв төсөл (ТВС).....	26
6.2. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11C).....	28
6.3. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP)	29
ДОЛОО. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	32
7.1. Бизнес инкубатор, сургалтын төв төсөл (ТВС).....	32
7.2. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11C).....	33
7.3. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP)	34
7.4. Салбар шугамын холболтын ажил (SC-A болон B)	35
НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	36
8.1. Бизнес инкубатор, сургалтын төв төсөл (ТВС).....	36
8.2. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11C).....	36
8.3. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP)	37
8.4. Салбар шугамын холболтын ажил (HSSC-C)	37
ЕС. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	38
9.1. Бизнес инкубатор, сургалтын төв төсөл (ТВС).....	38
9.2. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11C).....	38
9.3. Толгойт үерийн сувгийг тохижуулах багц ажил (TFP)	39
ДҮГНЭЛТ.....	41

ТОВЧИЛСОН ҮГС

АХБ	Азийн Хөгжлийн Банк
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
БОМТ	Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө
БОМТБТ	Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөний биелэлтийн тайлан
БОХШХ	Байгаль Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр
БОНЕҮ	Байгаль Орчны Нөлөөллийн Ерөнхий Үнэлгээ
БОННҮ	Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээ
БОХХ	Байгаль Орчны Хөндлөнгийн Хяналт
ШДТ	Шархад Дэд Төв
ЕХОБ	Европын Хөрөнгө Оруулалтын Банк
ЗДХ	Зөвшөөрөгдөх Дээд Хэмжээ
БОХЗТЛ	Байгаль Орчны Хэмжилзүйн Төв Лаборатори
НЗДТГ	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
НБОГ	Нийслэлийн байгаль орчны газар
НӨ	Нөлөөлөлд Өртөх
ТДТ	Толгойт Дэд Төв
ГХХХОДХ	Гэр Хорооллыг Хөгжүүлэх, Хөрөнгө Оруулалтыг Дэмжих Хөтөлбөр
ТУН	Төслийн Удирдах Нэгж

НЭГ. ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Ерөнхий мэдээлэл

Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Нийслэлийн Засаг Даргын Тамгын газарт хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага баримт бичгийн дагуу хотын гэр хорооллын дэд бүтэц, нийтийн ахуйн үйлчилгээг сайжруулах, тогтвортой хөгжүүлэхэд чиглэгдсэн арван жилийн хугацаатай хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл юм. Энэхүү хөтөлбөрөөс хүлээгдэж буй үр дүн, нөлөөлөл нь Улаанбаатар хотын амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах явдал юм. Энэхүү хөтөлбөрийн гол зорьж буй үр дүн нь Улаанбаатар хотын гэр хорооллыг тогтвортой, олон талыг хамардаг, сайн-бүтэцтэй болгон хөгжүүлэх явдал юм. Хөтөлбөрөөс гарах үр дүн нь:


- (i) Эдийн засгийн боломжууд, байшин барилга барих, хөдөлмөр эрхлэх боломж олгох, байгаль орчинд үүсэх нөлөө, тухайлбал: хөрс, агаарын бохирдолтой холбогдох нөлөөг багасган дэд төвүүдийг хөгжил сайтай бүс болгох;
- (ii) Ус хангамж, бохир ус, дүүргийн халаалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг санхүүгийн хувьд бие даасан өндөр чанартай үйлчилгээ үзүүлдэг болгох зорилгоор орчин үеийн тоног төхөөрөмж ашиглах боломжтой болгох;
- (iii) Зах зээлийн таатай орчин, зохистой хууль эрх зүйн орчинд үндэслэсэн оновчтой, олон нийтээр идэвхтэй оролцдог өсөлтөд чиглэсэн хот төлөвлөлтийн тогтолцоог бий болгох зэрэг юм. 2023 оны 11 дугаар сарын байдлаар Толгойт дэд төвд хамаарагдах бизнес инкубатор, сургалтын төв, үерийн хамгаалалтын далан, автозам, Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх ажил дэд бүтцийн төслийн үйл ажиллагаа, ус хангамжийн байгууламжийн бүтээн байгуулалт явагдаж байна.

Толгойт дэд төв төслийн хүрээнд нийт 27 ажил хамаарч байгаагаас 2023 оны 10-р сарын байдлаар 8 ажил эхлэсэн, 4 ажил дууссан байна.

Толгойт дэд төвийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ) 2020 онд БОАЖЯ-аар батлагдсан. Батлагдсан БОННУ хамтаар 2020-2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) батлагдсан. Энэхүү төрийн захиргааны байгууллагаас батлагдсан төлөвлөгөөний дагуу Толгойт дэд төвийн 2023 оны биелэлт, хэрэгжилтийн тайланг 2019 оны 10-р сарын 29-ны өдөр Байгаль орчин, Ногоон хөгжлийн яамны сайдын баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” А-618 дагуу боловсруулав.

1.2. Төслүүдийн товч танилцуулга, хэрэгжилтийн байдал

Толгойт дэд төв төслийн хүрээнд нийт 27 ажил хамаарч байгаагаас 2023 оны 11-р сарын байдлаар 8 ажил эхлэсэн, 4 ажил дууссан байна.



Зураг 1. Толгойт дэд төвийн хүрээнд хэрэгжих төслүүдийн байршил

ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хүснэгт 1. Төслүүдийн ерөнхий мэдээлэл болон 2023 оны хэрэгжилтийн байдал

№	Багцын дугаар	Багцын нэр	Гүйцэтгэгчид	Байришил	2023 оны явц
1	TEC-A	Толгойт дэд төвийн мэдээлэл холбооны шугам сүлжээ ба цахилгаан хангамжийн эх үүсвэрийн угсралт			Ажил эхлээгүй.
2	TEC-B	Толгойт дэд төвийн цахилгааны хаалттай дэд өртөө ба 10кВ цахилгаан дамжуулах кабель шугам			Ажил эхлээгүй.
3	TEC-C	Толгойт дэд төвийн цахилгааны хуваарилах байгууламжууд ба 10кВ-ын цахилгаан дамжуулах кабель шугам			Ажил эхлээгүй.
4	TRDH11A	Толгойт дэд төвийн авто зам болон дагалдах ИШС (3-р хэсэг)			Ажил эхлээгүй.
5	TRDH11B	Толгойт дэд төвийн авто зам болон дагалдах ИШС (4-р хэсэг)	“НАБСАН” ХХК		Ажил эхлээгүй.
6	TRDH11C	Толгойт дэд төвийн насосын станц болон усан шугам сүлжээ			Ажил эхлээгүй.
7	TRDH11D	Толгойт дэд төвийн авто зам			Ажил эхлээгүй.
8	TRDH14A	Толгойт дэд төвийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (1-р хэсэг)			
9	TRDH14B	Толгойт дэд төвийн авто зам, дулааны сүлжээ болон бусад дагалдах ИШС (2-р хэсэг)			
10	TBC	Толгойт дэд төв сургалтын төв	“Мандалт констракшин” ХХК		Толгойт дэд төвийн бизнес инкубатор, сургалтын төвийн ажил нь 2023 оны 04 сарын 10-ний өдрөөс эхэлсэн ба 2023 оны 09 сарын 25-ний байдлаар ажлын явц 75.0%-тай явагдаж байна. 2023 оны 11 сарын 30-нд барилгын ажлыг дуусгаж улсын коммист хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. “Мандалт Констракшин” ХХК нь барилгын ажлын явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдлөг болгон ажиллаж байна.
11	PHC	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний төв			Ажил эхлээгүй.
12	SHTL-A	Толгойтын дэд төвүүдийн ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбай (Ландшафтын байршил 1,2,3,4			Ажил эхлээгүй.
13	SHTL-B				
14	SHTL-C				
15	SHTL-D				

ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

16	SHTL-E	81-р цэцэрлэгийн зүүн талд гадна тохижилтын ажил			
17	TSC	Толгойт дэд төвийн бага сургууль. 320суудалтай, Ерөнхий боловсролын дунд сургууль			Ажил эхлээгүй.
18	SC-A	Дэд төвийн байршлын талбайн цэвэрлэгээний ажил (1-р шат ,2-р шат)	“ЗМЗ” ХХК	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг, 1 болон 34-р хороо Толгойт дэд төв	Газар шорооны ажил, хог хаягдал цэвэрлэгээ, ачилт, газар хэлбэржүүлэлт, тэгшилгээний ажил хийгдсэн.
20	SHTSC	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх ажил			
21	TFP	Толгойт дэд төвийн үерийн усны хамгаалалтын суваг (1-р хэсэг)			Тус үерийн далангийн барилгын ажлыг 2023 оны 10 дугаар сард дуусган дүүрэгт хүрээлэн өгөхөөр зорилго тавин ажиллаж байна.
22	SHTSC-A	Толгойтын ус, бохир ус, дулааны хоёрдогч холболт (Цэргийн хотхон)			Ажил эхлээгүй.
23	SHTSC-B	Баянхошуу дэд төв(Оргил)-ийн цэвэр, бохир ус, халуун ус, дулаан түгээх шугам сүлжээний нийлүүлэлт, суурилуулалт			Ажил эхлээгүй.
24	SHTSC-C	Дэд төвүүдийн бохир ус, дулааны хоёрдогч холболт			Ажил эхлээгүй.
25	SHTSC-D	Дэд төвүүдийн бохир ус, дулааны хоёрдогч холболт			Ажил эхлээгүй.
26	TFP-A	Толгойт дэд төвийн үерийн усны хамгаалалтын суваг (2-р хэсэг)	“Монгол менежмент” ХХК		Ажил эхлээгүй.
27	TFS	106-р сургуулийн хөлбөмбөгийн талбай.			Ажил эхлээгүй.

2023 онд хэрэгжиж эхэлсэн 8 ажлын танилцуулга

1. TBC – 72%
2. TFP – 90%
3. TRDH11C – 19.7%
4. SC-A – 100%
5. SC-B – 100%
6. SHTSC – 90%
7. SHTSC - B 3%
8. TFP-A – 8%

Зураг	Агуулга	Утга
	Дэд төвийн нэр:	Толгойт дэд төв
	Гэрээний дугаар:	TBC
	Гүйцэтгэгч:	“Мандалт констракшн” ХХК
	Байршил:	Улаанбаатар хот Сонгино хайрхан дүүрэг 1-р хороо
	БОННУ огноо:	2022
	Ажил эхэлсэн огноо:	2022 оны 3-р улирал
	Ажил дууссан огноо:	2024 оны 4-р улирал
	Зорилго:	Дэд төвийн байршлын талбайн цэвэрлэгээний ажил
	Ажлын хэмжээ:	Толгойт дэд төвд 4695 м2 талбайд 2 давхар бүхий 2 блок сургалтын төв баригдахаар төлөвлөгдсөн. Үүнээс 1-р давхарт номын сан, лекцийн танхим, цахилгааны өрөө, халаалтын зуухны өрөө, бие засах өрөө, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан сургалтын өрөө, багшийн өрөө болон захиргаа, аж ахуйн өрөө баригдах бол 2-р давхарт зөвлөх өрөө, сургалтын өрөө, хурлын өрөө, маркетингийн өрөө, жижиг дунд үйлдвэрлэлийн өрөө болон ажилчдын өрөө баригдана.

Зураг	Агуулга	Утга
	Дэд төвийн нэр:	Толгойт дэд төв
	Гэрээний дугаар:	TFP
	Гүйцэтгэгч:	Монгол менежмент ХХК
	Байршил:	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 1,34-р хороонутаг дэвсгэрт хэрэгжих 4 га талбайг хамарч байна.
	БОННУ огноо:	2022
	Ажил эхэлсэн огноо:	2023
	Ажил дууссан огноо:	
	Зорилго:	Толгойт дэд төвийн үерийн усны хамгаалалтын суваг
	Ажлын хэмжээ:	Толгойт дэд төвийн үерийн хамгаалалт, ус зайлуулах <ul style="list-style-type: none"> • Үерийн усны хамгаалалтын суваг • Тунгаах байгууламж 2ш • Далд хоолой 2 байрлалд

**ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Зураг	Агуулга	Утга
		<ul style="list-style-type: none"> Одоо байгаа далд хоолойг өргөсгөх 1 байрлалд Автомашин болон явган хүний гарц 2 байрлалд

Зураг	Агуулга	Утга
	Дэд төвийн нэр:	Толгойт дэд төв
	Гэрээний дугаар:	TRDH11C
	Гүйцэтгэгч:	“НАБСАН” ХХК
	Байршил:	Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр 2890м бүхий талбайг хамарна.
	БОННУ огноо:	2022
	Ажил эхэлсэн огноо:	2023 оны 09-р сар
	Ажил дууссан огноо:	2024 оны 09-р сар
	Зорилго:	Толгойт дэд төвийн насосын станц болон усан шугам сүлжээ
Ажлын хэмжээ:	<ul style="list-style-type: none"> Усан хангамжийн сүлжээ Ус хангамжийн шугам хоолой ба худгууд Насос станц Q=4600m³/х Насос станцын иж бүрэн барилга байгууламж, гадна тохижилт, зам талбай Одоо байгаа цахилгааны 10кВ, 0.4кВ-н кабель шугамыг шилжүүлэх, буулгах ба шинээр татах 	

Зураг	Агуулга	Утга
	Дэд төвийн нэр:	Толгойт дэд төв
	Гэрээний дугаар:	SC-A
	Гүйцэтгэгч:	ЗМЗ ХХК
	Байршил:	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг, 1 болон 34-р хороо Толгойт дэд төв
	БОННУ огноо:	2022
	Ажил эхэлсэн огноо:	2023
	Ажил дууссан огноо:	2024
	Зорилго:	Дэд төвийн байршлын талбайн цэвэрлэгээний ажил
Ажлын хэмжээ:	Баянхошуу, Дамба, Толгойт 160 нэгж талбар	

**ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Зураг	Агуулга	Утга
		

Зураг	Агуулга	Утга
	Дэд төвийн нэр:	Толгойт дэд төв
	Гэрээний дугаар:	SHTSC
	Гүйцэтгэгч:	
	Байршил:	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг
	БОННУ огноо:	2022
	Ажил эхэлсэн огноо:	2023
	Ажил дууссан огноо:	2024
	Зорилго:	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй сургууль цэцэрлэгүүдийн дэд бүтцийг бие даасан дэвшилтэт технологиор шийдвэрлэх ажил
	Ажлын хэмжээ:	<ul style="list-style-type: none"> Хийн халаалтын зуух суурилуулах ажил 9 ш сургууль Нөөц цахилгаан үүсгэвэр суурилуулах ажил - 4 сургууль Ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажил - 5ш сургууль Бохир усны саармагжуулах төхөөрөмж суурилуулах ажил - 1ш сургууль

Зураг	Агуулга	Утга
	Дэд төвийн нэр:	Толгойт дэд төв
	Гэрээний дугаар:	SHTSC - B
	Гүйцэтгэгч:	
	Байршил:	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг
	БОННУ огноо:	2022
	Ажил эхэлсэн огноо:	2023
	Ажил дууссан огноо:	2024
	Зорилго:	Баянхошуу дэд төв(Оргил)-ийн цэвэр, бохир ус, халуун ус, дулаан түгээх шугам сүлжээний нийлүүлэлт, суурилуулалт
	Ажлын хэмжээ:	<ul style="list-style-type: none"> Ариутгах татуургын шугам - 3км

**ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Зураг	Агуулга	Утга
		<ul style="list-style-type: none"> Гадна цэвэр усны шугам - 1,6км Дулаан хангамжийн шугам - 2км УДДТ-2ш

Зураг	Агуулга	Утга
	Дэд төвийн нэр:	Толгойт дэд төв
	Гэрээний дугаар:	ТФР-А
	Гүйцэтгэгч:	Монгол менежмент ХХК
	Байршил:	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг, 1 болон 34-р хороо Толгойт дэд төв
	БОННУ огноо:	2022
	Ажил эхэлсэн огноо:	2023, 6 сар
	Ажил дууссан огноо:	2024, 8 сар
	Зорилго:	Толгойт дэд төвийн үерийн усны хамгаалалтын суваг (2-р хэсэг)
Ажлын хэмжээ:	Толгойт дэд төвд (Баруун наран) үерийн хамгаалалт, ус зайлуулах хоолой <ul style="list-style-type: none"> Үерийн усны хамгаалалтын суваг Автомашин болон явган хүний гарц 5 байрлалд Далд хоолой 	

ХОЁР. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1. БОМТ 2023 оны биелэлтийн зорилго, зорилт

БОМТ нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төслийн талбай, түүний орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, хянах үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Энэхүү төлөвлөгөөний биелэлтийг хянуулж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

1. БОМТ-д тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажилчдын үүрэг хариуцлагын тогтоосон удирдлагын шатлал дараалал бий болно.
2. Ажилчид бүр байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэрэгцээ тэдэнд биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалт, ур чадвартай мэргэжилтэнтэй болсон байна.
3. Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилан тооцож, байгаль орчинд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, орчны чанарыг сайжруулах, хэвийн нөхцөлийг хадгалж, хамгаална.
4. Орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, иргэдтэй байгаль орчныг хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч, хамтран ажиллана.
5. Байгаль орчны асуудлаарх төрийн захиргаанаас өгсөн санал зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

НБОГ нь тухайн төслийн БОМТ-ийн биелэлтийн тайлантай танилцан хянаж ажиллана. БОМТ-ий биелэлт, хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, БОАЖЯ болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх нь төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг болно.

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1. Бизнес инкубатор, сургалтын төв төсөл (ТВС)

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Биелэлт буюу хэрэгжилт
1. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт				
1.1	Газар шорооны ажилд 0.23 га талбайн газрын гадарга, хэвлий өртөж эвдрэл үүсэх	Сургалтын төвийн эдэлбэр газрын 10%-аас доошгүй хэсэгт гадна орчны тохижилтын ажлууд хийж, мод зүлэг тарьж, ногоон байгууламж үүсгэх	Эдэлбэр газар	Бизнес инкубатор, сургалтын төвийн биологийн нөхөн сэргээлтийн ажил 11 сараас эхлэх ба төлөвлөгөөнд туссаны дагуу нийт 18 ширхэг мод тарих 1.2м урт, 1.2м өргөн, 0.8м гүн нүх ухаж бэлдэнэ. Мөн зургийн дагуу 45м урт ургамлын хашлага тарих 30 см өргөн 40 см гүнзгий суваг ухаж чулуутай хэсгийг ялган цэвэрлэж хар шороогоор сэлбэн бэлдсэн нүхэндээ мод тарих технологийн дагуу мод бутгаа 2024 оны 4 сард тарина. Тохижилт хийгдэх талбайд явган зам талбай хийж дууссаны дараа шороог тэгшлэн цэвэрлэж зүлэг тарих талбайн хэмжээнээс хамаарч техникээр болон гар ажиллагаагаар хөрсийг боловсруулж элсжүүлэн хөнгөн бүтэцтэй болгон хар шороо нэмж бууцаар бордож талбайг засна 20 см зузаан хөрсийг сайжруулж солино.
1.2	Газар шорооны ажлаас 3329м ³ хаягдал шороон материал үүсэх	Барилгын суурь ухах, гадна зам талбайн цэвэрлэгээ, тэгшилгээ зэрэг ажлуудаас үүсэх хаягдал шороон материалыг хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг СХД дүүргийн хот тохижилтын газраас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө.	Эдэлбэр газар	Сонгинохайрхан дүүргийн ТЦҮ-тэй 2023 оны 04-р сарын 25-ны өдөр 1465/1 тоот гэрээг байгуулсан. Тус гэрээний 6.1-т үйлдвэрлэлийн хог хаягдал гэж тусгасан байна (Хавсралт ТБС-1).
1.3		Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана.	Эдэлбэр газар	Төслийн талбайд түр хаягдлын цэг байгуулсан ба үйл ажиллагаанаас үүдэлтэй ахуйн болон барилгын хог хаягдлыг нэг цэгт цуглуулан сард 2 удаа ачуулан хаядаг (Хавсралт ТБС-2).
1.4	Газрын гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орох	Газар шорооны ажлаас бий болох шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох	Эдэлбэр газар	Хаягдал шороон материал болон барилгын хог хаягдлыг эдэлбэр газрын хашаа дагуулан орц, гарц, дотоод тээврийн зам, хөдөлгөөнд саад учруулахгүй газар байршуулж ажилласан (Хавсралт ТБС-3).
1.5		Хаягдал шороон материалын овоолгыг их хэмжээгээр хуримтлуулахгүйгээр тухай бүрд нь ачин зайлуулж байх	Эдэлбэр газар	Төслийн талбайд түр хаягдлын цэг байгуулсан ба үйл ажиллагаанаас үүдэлтэй ахуйн болон барилгын хог хаягдлыг нэг цэгт цуглуулан сард 2 удаа ачуулан хаядаг (Хавсралт ТБС-4).
2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө				
2.1	Газар шорооны ажил, талбайн тэгшилгээ хийх, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас тоосжилт үүсэж агаар орчныг бохирдуулах	Хуурай өдрүүдэд газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд м ² талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх	Барилгын ажил явагдаж буй эдэлбэр газар	Барилгын ажлын үед тоос дарах усалгааг 2 өдөрт 1 удаа, тоосжилт ихтэй үед өдөрт 2-аас доошгүй тоос дарах усалгааг хийсэн (Зураг 1).
2.2		Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоох	Барилгын ажил явагдаж буй эдэлбэр газар	Барилгын ажлын талбайн журам, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд заасны дагуу онц аюултай байгалийн үзэгдэл болох газар хөдлөлт, салхи, шороон шуурга, бороотой үед гадна орчинд гүйцэтгэж буй барилгын ажлыг түр зогсоож ажилласан.

ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2.3		Хүчтэй салхи шуургатай үед хөрсний овоолгоос тоосжилт үүсэхээс сэргийлж усалгаа хийх	Барилгын ажил явагдаж буй эдэлбэр газар	Түр овоолгуудыг хүчтэй салхи, шуургатай үед ачиж зайлуулсан байдаг учир усалгаа хийх шаардлагагүй байв.
2.4		Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Барилгын ажил явагдаж буй эдэлбэр газар	Төслийн үйл ажиллагааны тээвэрлэлтийн явцад хийгдсэн. Ачааны машины тэвхийг хэт дүүргэлгүй, 60 см орчим сул үлдээж, сайтар хучсан (Зураг 2).
2.5	Барилгын ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал, бохирдуулагч бодисууд ялгарч агаар орчныг бохирдуулах	Барилгын ажилд ашиглагдаж буй машинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх	Барилгын ажилд ашиглаж буй бүх тээврийн хэрэгсэл	Талбайд ажиллаж буй тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд хамруулсан бөгөөд өдөр бүр тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг харгалзан ажлын талбайд гаргадаг (Хавсралт ТБС-5).
2.6		Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношилгоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх	Барилгын ажилд ашиглаж буй бүх тээврийн хэрэгсэл	
2.7		Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын /MNS 5013:2009, MNS5014:2009/ дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах	Барилгын ажилд ашиглаж буй бүх тээврийн хэрэгсэл	
2.8	Барилгын ажлын үед цемент, элс зэрэг нунтаг бодисууд, мод төмрийн үртэс, хаягдал материалууд салхинд хийсэж орчны агаарт бохирдол үүсгэж болзошгүй	Барилгын ажил явагдаж буй цэгүүдэд талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж, барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тогтмол зайлуулж байх	Барилгын ажил явагдаж буй эдэлбэр газар	Төслийн талбайд түр хаягдлын цэг байгуулсан ба үйл ажиллагаанаас үүдэлтэй ахуйн болон барилгын хог хаягдлыг нэг цэгт цуглуулан сард 2 удаа ачуулан хаядаг (Хавсралт ТБС-2).
2.9		Дулааны эх үүсвэр гаргах буюу хаягдал материалыг устгах зорилгоор шатамхай материалыг ил талбайд шатаахыг хориглоно.	Барилгын ажил явагдаж буй эдэлбэр газар	Хог хаягдал ил задгай шатаагаагүй бөгөөд тухай бүрд нь цэвэрлэж гэрээний дагуу тээвэрлэж байсан болно.
3. Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө				
3.1	Газар шорооны ажил, барилга угсралтын ажил, барилгын материал тээвэрлэх, ачих, буулгах ажлуудаас дуу чимээ үүсэх	Барилгын ажилд ашиглагдаж буй машинуудыг техникийн үзлэг, оношилгоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Талбайд ажиллаж буй тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд хамруулсан бөгөөд өдөр бүр тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг харгалзан ажлын талбайд гаргадаг (Хавсралт ТБС-5).
		Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Өдөр бүр 8:00-19:00 цагийн хооронд ажилласан бөгөөд дуу чимээний асуудлаар иргэдээс гомдол санал ирээгүй болно.
		Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	3 удаа дуу чимээний шинжилгээ хийсэн (Хавсралт ТБС-6).
3.2	Барилгын болон ахуйн хог хаягдлыг зүй зохистойгоор цуглуулж,	СХД-ийн тохижилт үйлчилгээний газартай хог хаягдлын гэрээ байгуулж, түүнд хаягдал шороон материал, ахуйн ба барилгын хог хаягдлыг зайлуулах цэг	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Сонгинохайрхан дүүргийн ТЦҮ-тэй 2023 оны 04-р сарын 25-ны өдөр 1465/1 тоот гэрээг байгуулсан. Тус гэрээний 6.1-т үйлдвэрлэлийн хог хаягдал гэж тусгасан байна (Хавсралт ТБС-1).

ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

	зайлуулаагүйгээс физик орчны бохирдол үүсгэх	ба тээвэрлэх автомашины улсын дугаарыг тодорхой зааж өгөх		
		Барилгын ажил явагдаж буй газруудад хогийн хаягдлын цэг тогтоож, зориулалтын хогийн сав байрлуулах	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Энгийн хог хаягдлын 3 ангилал бүхий хогийн сав байршуулсан (Хавсралт ТВС-7). Тус төсөл дулааны улиралд хэрэгжих учир үнсний хаягдал гарахгүй гэж үзсэн болно.
		Барилгын түр кемп тус бүрд хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж, тэмдэгжүүлэх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Барилгын ажил явагдаж буй талбайн урд талд хог хаягдлын нэгдсэн цэгийг байршуулсан.
		Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Хаягдал шороон материал болон барилгын хог хаягдлыг эдэлбэр газрын хашаа дагуулан орц, гарц, дотоод тээврийн зам, хөдөлгөөнд саад учруулахгүй газар байршуулж ажилласан. Ахуйн гаралтай буюу энгийн хог хаягдлыг энгийн хог хаягдлын цэгт түр хадгалсан.
		Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавьж ажилласан болно.
		Барилгын түр кемпүүдээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Нүхэн жорлон ашигладаг. Нүхэн жорлонгийн эзлэхүүн 70% болох үед нь зөвшөөрөлтэй аж ахуй нэгжээр соруулж ариутгал хийлгэсэн (Хавсралт ТВС-8).
		Барилгын ажил дууссаны дараа хог хаягдлыг цуглуулж зайлуулах, талбайн цэвэрлэгээг бүрэн гүйцэд хийж хяналтын инженерт хүлээлгэн өгөх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Төслийн талбайд түр хаягдлын цэг байгуулсан ба үйл ажиллагаанаас үүдэлтэй ахуйн болон барилгын хог хаягдлыг нэг цэгт цуглуулан сард 2 удаа ачуулан хаядаг (Хавсралт ТВС-2).
4. Гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө				
4.1	Их хэмжээний хур бороо орсны улмаас барилгын ажил явагдаж буй зам, талбай үерт автаж, машин техник эвдэрч гэмтэх, хүн осолдох	Онцгой байдлын төлөвлөгөө боловсруулж ажиллах, түүнд үерийн эрсдэлээс хамгаалах зохих арга хэмжээнүүдийг тусгаж өгөх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Зураг төслийн шатанд их үерийн тооцоо, судалгааг хийж, үерийн аюулаас хамгаалах шийдлийг гаргаж өгсөн бөгөөд энэхүү зураг төслийн дагуу ажиллаж байна.
4.2	техник эвдэрч гэмтэх, хүн осолдох	Барилгын түр кемпүүд, бүх инженерийн байгууламжууд нь үерээс хамгаалах байгууламжтай байх (үерээс хамгаалах далан, шуудуу зэрэг)	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	
4.3	Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч, хур борооны усаар зөөгдөх буюу хөрсөнд нэвчих байдлаар гадаргын болон газрын доорх усны бохирдол үүсгэх	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	ШТМ-ын агуулах байхгүй.
4.4	нэвчих байдлаар гадаргын болон газрын доорх усны бохирдол үүсгэх	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Талбайд ажиллаж буй тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд хамруулсан бөгөөд өдөр бүр тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг харгалзан ажлын талбайд гаргадаг (Хавсралт ТВС-5).
4.5		Шатах тослох материал асгарсан үед, хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	ШТМ хөрсөнд асгарах үед шингээх зорилгоор үртсийг байнгын бэлэн байдалд байлгасан.

ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

4.6	Барилгын болон ахуйн зориулалтаар багавтар хэмжээний ус ашиглах	Үйл ажиллагаанд шаардагдах усны эх үүсвэр, хэрэглээг тогтоож, ус ашиглалтын гэрээ байгуулж ажиллах	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Барилгын үйл ажиллагаа болон тоосжилт бууруулах усны хэрэглээг ус түгээх байрнаас зөврөөр ус авч ашигласан. Унд ахуйн хэрэглээнд савласан баллонтой ус ашигласан.
4.7		Ашиглаж буй усны хэмжээ, чанарт хяналт тавьж ажиллах	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Усны шинжилгээг хийсэн. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтээс үзнэ үү.
4.8	Шингэн хаягдал, 00-д хуримтлагдсан ялгадас зэрэг нь хөрсөнд нэвчиж газрын доорх усны найрлага, чанарт нөлөөлж болзошгүй.	Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Нүхэн жорлон ашигладаг. Нүхэн жорлонгийн эзлэхүүн 70% болох үед нь зөвшөөрөлтэй аж ахуй нэгжээр соруулж ариутгал хийлгэсэн (Хавсралт ТВС-8).
4.9		Барилгын түр кемпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлорамин цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	
5. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө				
5.1	Машин тэрэг, хүний байнгын хөл хөдөлгөөнөөс үүдэн хөрс суларч доройтох, хөрсний элэгдэл үүсэж болзошгүй	Хөрсний эвдрэл талхагдал үүсэхээс сэргийлж хүнд даацын машинуудыг тогтсон маршрутаар зорчуулах	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Барилгын талбайгаас хатуу хучилттай зам хүртэл 80 м бөгөөд энэ дагуу шороон замаар тээвэрлэлт хийж байна.
5.2		Барилгын ажил дуусах үед хөрс суларч доройтон, хөрсний элэгдэл үүссэн газруудад нөхөн сэргээлт хийх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Гадаад тээвэрлэлтийн шороон замд хайрган хучилт хийж элэгдэл, эвдрэлд орохоос урьдчилан сэргийлсэн (Зураг 3).
5.3	Газар шорооны ажлын улмаас 0.23 га талбайн өнгөн хөрс хуулагдаж эвдрэлд орох ба шимт хөрсний овоолгыг стандартын дагуу үүсгэж хадгалаагүй нөхцөлд хөрсний чанар алдагдаж болзошгүй	Барилгын суурь ухах, гадна зам талбайн цэвэрлэгээ, тэгшилгээ зэрэг ажилд өртөж эвдэрсэн 0.23 га талбайд талбайд барилгын ажил дуусмагц нөхөн сэргээлт, тохижилтын ажлууд хийж, мод зүлэг тарих	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Техникийн нөхөн сэргээлтийн ажлын үед талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, шаардлагатай газарт нь хөрсөөр хучих зэрэг ажлууд хийгдэж байна.
5.4		Газар шорооны ажлын үед өнгөн хөрсний овоолгыг тусад нь үүсгэж стандартын дагуу хадгалах ба барилгын ажил дуусах үед нөхөн сэргээлтэд ашиглах	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Эдэлбэр газар бүхэлдээ хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон, хог хаягдал бүхий үе үүссэн техноген гаралтай хөрстэй байсан учир шимт хөрс хуулалт хийгдээгүй болно.
5.5		Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Төслийн талбайд ШТС байхгүй.
5.6	Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч хөрсөнд нэвчсэнээр хөрсөн бүрхэвчийн бохирдол үүсгэж болзошгүй.	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгаж хөдөлгөөн оролцуулсан.
5.7		Бетон зуурмаг, асфальт материал тээвэрлэх, буулгах, хучилт хийх ажлуудыг нарийн чанд горимын дагуу тогтоосон талбайн хүрээнд гүйцэтгэж, хөрсөнд асгаралт үүсгэхээс сэргийлэх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Бетон зуурмаг, асфальт материал болон бусад төрлийн барилгын материалын асгаралт явагдаагүй болно.

ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

5.8	Хог хаягдал, кемпээс гарах бохир ус, бие засах газар, ахуйн бохирдол зэргээс үүдэлтэй хөрсний бохирдол үүсэж болзошгүй.	Барилгын ба ахуйн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж тэмдэгжүүлэх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Энгийн хог хаягдлын 3 ангилал бүхий хогийн сав байршуулсан. Барилгын хог хаягдлыг өмнө ашиглаж ирсэн хогийн цэгт түр хадгалж байна.
5.9		Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Сонгинохайрхан дүүргийн ТЦУ-тэй 2023 оны 04-р сарын 25-ны өдөр 1465/1 тоот гэрээний дагуу зайлуулж байна.
5.10		Барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Нүхэн жорлон ашиглаж байна (Хавсралт ТВС-8).
5.11		Барилгын түр кемпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлорамин цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Нүхэн жорлонгийн эзлэхүүн 70% болох үед нь соруулж, ариутгал хийлгэсэн (Хавсралт ТВС-8).
6. Түүх соёлын өвд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ				
6.1	Газар шорооны ажлын явцад газрын хөрсөнд нуугдмал байсан	Санамсаргүй олдвор илэрсэн цэгт барилгын үйл ажиллагааг нэн даруй зогсоох	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Түүх, соёл, археологийн олдвор барилгын ажлын үед ажиглагдаагүй, илрээгүй болно.
6.2	археологи, палеонтологийн санамсаргүй олдвор, илэрч болзошгүй	Санамсаргүй олдвор илэрсэн тухай дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Түүх, соёл, археологийн олдвор барилгын ажлын үед ажиглагдаагүй, илрээгүй болно.
6.3		Археологийн хүрээлэнгийн мэргэжлийн баг ажиллуулж шаардлагатай судалгаа шинжилгээ хийлгэх, шаардлагатай бол авран хамгаалах малтлага хийлгэх	Барилгын ажлын талбай, барилгын түр кемп	Түүх, соёл, археологийн олдвор барилгын ажлын үед ажиглагдаагүй, илрээгүй болно.

3.2. Дэд бүтцийн байгууламжууд (TRDH11C)

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Биелэлт буюу хэрэгжилт
1. Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт				
1.1	Газар шорооны ажлаас нийт 0.4 га талбайн газрын гадарга эвдрэлд өртөнө	Дэд бүтцийн байгууламжийн ажилд өртөж эвдэрсэн 0.4 га талбайд талбайд газар шорооны ажил дуусмагц нөхөн сэргээлт, тэгшилгээний ажлууд хийж, хэлбэршүүлэх, орчны тохижилт үүсгэх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Дэд бүтцийн байгууламжийн ажилд өртөж эвдэрсэн газарт хэлбэржүүлэлт, тэгшилгээний ажлыг тухай бүрд нь хийж гүйцэтгэсэн (Хавсралт TRDH11C-1).
1.2	Газар шорооны ажлаас хаягдал шороон материал үүсэх	Газар шорооны ажлаас үүсэх хаягдал шороон материалыг хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэн зайлуулах зөвшөөрлийг СХД дүүргийн хот тохижилтын газраас авч, хог хаягдлын гэрээнд тусган оруулж өгнө.	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Хог хаягдлын гэрээг хараахан байгуулж амжаагүй байгаа ба газар чөлөөлөлт, газар шорооны ажил хийгдэж байгаа ба энэхүү ажлуудын хүрээнд гарсан хог хаягдлыг Нарангийн хогийн цэгт тухай бүрд нь хүлээлгэн өгч байна.
1.3		Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын хэмжээ, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлж, 7 хоног бүр ТУН-д тайлагнана.	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Тайлагнан ажиллаж байна.

ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

1.4	Газрын гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орох	Авто зам ба дулаан, цэвэр, бохир ус, дренажийн шугам хоолой тавих газар шорооны ажлуудаас бий болох шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд саад учруулахгүйгээр төлөвлөн ажиллаж байна.
1.5		Газар шорооны ажил дуусмагц шороон материалын овоолго байрлаж байсан цэгт талбайн цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Тухай бүрд нь газар шорооны ажилд өртсөн газрыг хэлбэршүүлэх, тэгшлэх ажлууд хийгдсэн (Хавсралт TRDH11-C-1).
2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө				
2.1	Газар шорооны ажил, талбайн тэгшилгээ хийх, барилгын материал тээвэрлэх, ачиж буулгах зэрэг ажлуудаас тоосжилт үүсэж агаар орчныг бохирдуулах	Хуурай өдрүүдэд газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд м ² талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгааг хийх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Газар шорооны ажлын үед тоос дарах усалгааг 2 өдөрт 1 удаа, тоосжилт ихтэй үед өдөрт 2-аас доошгүй тоос дарах усалгааг хийсэн.
2.2		Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоох	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс ачиж буулгах болон газар шорооны ажлыг түр зогсоож ажилласан
2.3		Хүчтэй салхи шуургатай үед газар шорооны ажлаас тоосжилт үүсэхээс сэргийлж усалгаа хийх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Хүчтэй салхи, шуургагүй үед ажилласан учир усалгаа хийх шаардлагагүй байв.
2.4		Хаягдал шороон материал, барилгын материал тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн ачааг хучиж бүтээх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Төслийн үйл ажиллагааны тээвэрлэлтийн явцад хийгдсэн. Ачааны машины тэвшийг хэт дүүргэлгүй, 60 см орчим сул үлдээж, сайтар хучсан.
2.5	Барилгын ажилд ашиглагдах тоног төхөөрөмж, машин механизмаас хийн хаягдал, бохирдуулагч бодисууд ялгарч агаар орчныг бохирдуулах	Ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Талбайд ажиллаж буй тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд хамруулсан бөгөөд өдөр бүр тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг харгалзан ажлын талбайд гаргадаг.
2.6		Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношилгоо үйлчилгээг тогтмол, чанартай хийх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	
2.7		Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын /MNS 5013:2009, MNS5014:2009/ дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	
2.8	Барилгын ажлын үед цемент, элс зэрэг нунтаг бодисууд, мод төмрийн үртэс, хаягдал материалууд салхинд хийсэж орчны агаарт бохирдол үүсгэж болзошгүй	Газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж, барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тогтмол зайлуулж байх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Төслийн талбайд үүссэн барилгын хог хаягдлыг тухайн үед нь ачуулан Нарангийн энгэрийн хог хаягдлын цэгт хаядаг (Хавсралт TRDH11-C-1).
2.9		Дулааны эх үүсвэр гаргах буюу хаягдал материалыг устгах зорилгоор шатамхай материалыг ил талбайд шатаахыг хориглоно.	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	
3. Физик орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө				
3.1	Газар шорооны ажил, барилга угсралтын ажил, барилгын материал тээвэрлэх, ачих, буулгах ажлуудаас дуу чимээ үүсэх	Зам, барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэг, оношилгоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Талбайд ажиллаж буй тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд хамруулсан бөгөөд өдөр бүр тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг харгалзан ажлын талбайд гаргадаг.
		Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	

ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

		Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Дуу шуугианы хэмжилт хийсэн. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс үзнэ үү.
		Барилгын ажил явагдаж буй газруудад хогийн хаягдлын цэг тогтоож, зориулалтын хогийн сав байрлуулах	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Хогийн сав байршуулан ажилласан
		Барилгын түр кемп тус бүрд хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэг тогтоож, хашлага хамгаалалт хийж, тэмдэгжүүлэх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Газар чөлөөлөлт болон газар шорооны ажлын үед үүсэх хог хаягдлыг тойруулан туузан анхааруулах зурвас байгуулж ажилласан.
		Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Газар чөлөөлөлт болон газар шорооны ажлын үед үүсэх хог хаягдлыг тухай бүрд нь зайлуулж ажилласан.
		Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Газар чөлөөлөлт болон газар шорооны ажлын үед үүсэх хог хаягдлыг тухай бүрд нь зайлуулж ажилласан.
		Барилгын түр кемпүүдээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Нүхэн жорлон ашигладаг. Тус нүхэн жорлон нийт эзлэхүүний 70%-д хүрээгүй байна.
		Барилгын ажил дууссаны дараа хог хаягдлыг цуглуулж зайлуулах, талбайн цэвэрлэгээг бүрэн гүйцэд хийж хяналтын инженерт хүлээлгэн өгөх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Төслийн талбайд түр хаягдлын цэг байгуулсан ба үйл ажиллагаанаас үүдэлтэй ахуйн болон барилгын хог хаягдлыг нэг цэгт цуглуулан сард 2 удаа ачуулан хаядаг (Хавсралт ТБС-2).
4. Гадаргын ба газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө				
4.1	Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч, хур борооны усаар зөөгдөх буюу хөрсөнд нэвчих байдлаар гадаргын болон газрын доорх усны бохирдол үүсгэх	Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	ШТМ-ын агуулах байхгүй.
4.2		Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Талбайд ажиллаж буй тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд хамруулсан бөгөөд өдөр бүр тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг харгалзан ажлын талбайд гаргадаг.
4.3		Шатах тослох материал асгарсан үед, хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	ШТМ хөрсөнд асгарах үед шингээх зорилгоор үртсийг байнгын бэлэн байдалд байлгасан.
4.4	Барилгын болон ахуйн зориулалтаар багавтар хэмжээний ус ашиглах	Үйл ажиллагаанд шаардагдах усны эх үүсвэр, хэрэглээг тогтоож, ус ашиглалтын гэрээ байгуулж ажиллах	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Технологийн болон унд ахуйн усны хэрэглээг ус түгээх байрнаас зөврөөр ус авч ашигласан.
4.5		Ашиглаж буй усны хэмжээ, чанарт хяналт тавьж ажиллах	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Усны шинжилгээг хийсэн. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтээс үзнэ үү.
4.6	Шингэн хаягдал, 00-д хуримтлагдсан ялгадас зэрэг нь хөрсөнд нэвчиж газрын доорх усны найрлага, чанарт нөлөөлж болзошгүй.	Зам, барилгын түр кемпээс үүсэх шингэн хог хаягдлыг зориулалтын саванд цуглуулж, зөвшөөрөгдсөн цэгт зайлуулж байх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Нүхэн жорлон ашигладаг. Одоогоор тус нүхэн жорлон нийт эзлэхүүний 70%-д хүрээгүй байна.
4.7		Зам, барилгын түр кемпийн 00-н нүхэнд бактерийн бохирдлоос сэргийлэх био-бэлдмэл хэрэглэж, ойр орчмыг хлорамин цацлагаар тогтмол ариутгаж цэвэрлэж байх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	
5. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө				
5.1	Машин тэрэг, хүний байнгын хөл хөдөлгөөнөөс үүдэн хөрс суларч доройтох,	Хөрсний эвдрэл талхагдал үүсэхээс сэргийлж хүнд даацын машинуудыг тогтсон маршрутаар зорчуулах	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Газар шорооны ажлын үед ажиллаж буй тээврийн хэрэгсэл тус бүрийг нэгж маршрутаар явах заавар зөвлөгөөг тогтмол анхааруулж ажилласан.

ТОЛГОЙТ ДЭД ТӨВ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

5.2	хөрсний элэгдэл үүсэж болзошгүй	Зам, барилгын ажил дуусах үед хөрс суларч доройтон, хөрсний элэгдэл үүссэн газруудад нөхөн сэргээлт хийх	Дэд бүтцийн байгууламжийн ажил явагдаж буй талбай	Газар хэлбэржүүлэх, тэгшлэх ажлын тогтмол хийж ирсэн (Хавсралт TRDH11C-1).
